

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ
ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХОА-2024/20-20-ШТА-ГА

***Хүүхэд хамгаалалын үйлчилгээний талаарх тайлан, тоон
мэдээлэл зөрүүтэй, салбар хоорондын ажлын уялдаа сул байна.***

Ховд хот
2024 оны 10 дугаар сар

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061
Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нарантуул
Цахим хаяг: narantuuld@audit.gov.mn
Аудитор: У.Батчимэг
Цахим хаяг: batchimegu@audit.gov.mn
Аудитор: М.Энхжаргал
Цахим хаяг: enkhjargalm@audit.gov.mn

Тайланг хянасан:

Ховд аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор
Х.Болдбаатар

Тайланг бэлтгэсэн:

Аудитын менежер
А.Цэцэгсүрэн
Ахлах аудитор
Д.Нарантуул
Аудитор У.Батчимэг
Аудитор М.Энхжаргал

2024 оны 10 дугаар сар

Тайланг УАГ-ын
цахим хуудаснаас үзнэ
үү: www.audit.mn

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70432545 дугаарын утас,
70433061 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ:

Ховд аймгийн ЗДТГ-ын
байр 3 давхар

АГУУЛГА

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ 5

БҮЛЭГ 1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ТУСГАСАН Ч ХАМТАРСАН БАГУУДАД МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ НӨӨЦ ДУТАГДАЛТАЙ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДЭЭГҮЙ БАЙНА 6

Нийгмийн хэрэгцээ шаардлагад үндэслэн хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлэх ажлуудыг бодлогын баримт бичгүүдэд тусган баталсан байна6

Хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн албан хаагчид дутагдалтай, хүний нөөцийн тогтвортой байдал хангагдаагүй байна7

Хүүхэд хамгааллын талаарх мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй байна.....8

БҮЛЭГ 2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ СУЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ХАНГАГДААГҮЙ БАЙНА 10

Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийн сан бүрдээгүйгээс статистик тоо мэдээг үнэн зөв нэгтгээгүй, төсвийн төлөвлөлтийг бодитой тооцоогүй байна.....10

Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтын ил тод байдлыг бүрэн хангаагүй, төсвийн хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт сул, дотоод хяналт хэрэгжүүлээгүй, зарим хөрөнгө оруулалтын ажлууд үр дүнгүй хэрэгжсэн байна11

БҮЛЭГ 3: ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ХЯНАЛТЫГ ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА 16

Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлсэн хяналт сул, өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг тооцдоггүйгээс бий болсон үр нөлөө тодорхойгүй байна.....16

Боловсрол салбарт мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдсанаар сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээнд эерэг нөлөөлөл бий болж, хүүхэд хамгааллын статистик мэдээг нэгтгэн гаргадаг үр дүн бий болжээ.....18

ХГБХХГ нь эрүүл мэнд, соёл, спорт, хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагуудтай хүүхэд хамгааллын чиглэлээр үр нөлөөтэй хамтран ажиллах шаардлагатай байна19

ДҮГНЭЛТ 24

•

24

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ 25

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
ББНШК	Баримт бичиг нягтлан шалгах комисс
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар
ГБХЗЕГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын ерөнхий газар
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НҮТББ	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОУБ	Олон улсын байгууллага
СӨБ	Сургуулийн өмөнөх боловсрол
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТББ	Төрийн бус байгууллага
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХҮГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	2019-2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний талаарх мэдээлэл	7
Хүснэгт 2	Хүний нөөцийн мэдээлэл	7
Хүснэгт 3	Хүүхэд хамгааллын мэдээлэл	8
Хүснэгт 4	Хурдан морь унаач хүүхдийн мэдээлэл	9
Хүснэгт 5	Хүүхэд хамгааллын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
Хүснэгт 6	СТА-ийн дүгнэлт, алдаа зөрчлийн мэдээлэл	12
Хүснэгт 7	Хандивлагч байгууллагуудын мэдээлэл	12
Хүснэгт 8	Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардал	15
Хүснэгт 9	Эрүүл мэндийн салбарын мэдээлэл	19
Хүснэгт 10	Хүүхдийн тусламжийн 108 утасны мэдээлэл	21
Хүснэгт 11	Able программын мэдээлэл	21
Хүснэгт 12	Гэмт хэргийн мэдээлэл	22

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Хүүхдийн тусламжийн 108 утасны мэдээлэл	9
Дүрслэл 2	Хүүхэд хамгааллын үйлчилгээ	11
Дүрслэл 3	Батлагдсан төсөв хүүхэд хамгааллын зардал (2019-2023)	11
Дүрслэл 4	Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын зарцуулалт	12
Дүрслэл 5	Шилэн дансны хуулийн хэрэгжилт	12
Дүрслэл 6	Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлын 2023 оны зарцуулалт	15
Дүрслэл 7	Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага (орчин)	17
Дүрслэл 8	Боловсролын салбарын статистик мэдээлэл	18
Дүрслэл 9	Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээлэл	22

ЗУРАГ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1	2019-2023 оны төсвийн төсөл, батлагдсан төсөв	10
График 2	Able программ дахь эрсдэлийн төрөл	22
Зураг 1	Баянбулаг зусланд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын зураг	17

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Аудитын сэдэв батлах тухай”, 2023 оны А/152 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” тушаалуудын дагуу аудитыг гүйцэтгэв.
Аудитын зорилт	Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэв. Дээрх зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:
Аудитын хамарсан хүрээ	➢ Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх; ➢ Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх; ➢ Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх; Аудитад аймгийн ИТХ, ЗДТГ, ХГБХХГ, Цагдаагийн газар, БШУГ, ЭМГ, ХХҮГ зэрэг байгууллагуудын 2019-2023 онуудад хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, статистик мэдээ, хяналт шинжилгээ үнэлгээний тайлан, мэдээ судалгааг хамруулав.
Аудитын арга зүй	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлалын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав. Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: Хүүхдийн Эрхийн Тухай Конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулиуд болон Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл, Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймаг хөгжүүлэх 2021-2024 оны үндсэн чиглэл зэргийг шалгуур болгон авч үзлээ.
Хүндрэл бэрхшээл	Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын хүүхэд хамгаалал, гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллаагүй, байгууллагын архивын мэдээлэл иж бүрэн бус, нэгтгэн гаргасан жилийн эцсийн тоо, статистик мэдээлэл нь хоорондоо зөрүүтэй байгаа нь аудитыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байлаа.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хүүхэд хамгааллын тухай хууль нь анх 2016 онд батлагдсанаас хойш 6 удаагийн нэмэлт өөрчлөлт орж, 50 орчим журам, 8 стандартыг мөрдөж ажиллаж байна. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2023 онд батлагдсан бөгөөд 2024 оны 9 дүгээр сарын 1-ээс эхлэн дагаж мөрдөхөөр тусгажээ.

Хүүхэд хамгааллын тухай шинэчилсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д “хүүхэд хамгаалал” гэж нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн энэ хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг”, “Хүүхэд хамгааллын үйлчилгээ” гэдэг нь хүүхэд хамгааллын тогтолцооны оролцогч талуудаас хүүхдийн хамгуулах эрхийг хангах зорилгоор үзүүлж байгаа шуурхай тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг” хэлнэ гэж тус тус заажээ.

Хүүхэд хамгааллын талаар НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенц, Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл, Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т тус тус тусган хэрэгжүүлж байна.

Хүүхдийн тусламжийн утас олон улсын байгууллага 2003 онд байгуулагдсан, өнөөгийн байдлаар дэлхийн хэмжээнд 168 орны “халуун шугам буюу тусламжийн утас” буюу 173 хүүхдийн тусламжийн утас ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2023 онд хүүхдийн тусламжийн 108 утсанд 153 дуудлага, мэдээлэл ирснийг өмнөх онтой харьцуулахад 30.7 хувиар өссөн, хүүхэд хамгааллын үйлчилгээнд 1164 хүүхэд хамрагдсан нь өмнөх оноос 4.6 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Ховд аймгийн хэмжээнд Хүүхэд хамгааллын чиглэлээр 8 төрийн байгууллага, 18 Хүүхдийн төлөө зөвлөл, 17 суманд 29 хамтарсан баг үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүүхэд хамгааллын нөхцөл байдлын үнэлгээ, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023 онд 198.6 сая төгрөгөөр батлагдсан нь өмнөх оноос 77.4 сая, 2019 оноос 120.7 сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.

БҮЛЭГ 1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ТУСГАСАН Ч ХАМТАРСАН БАГУУДАД МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ НӨӨЦ ДУТАГДАЛТАЙ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДЭЭГҮЙ БАЙНА

Нийгмийн хэрэгцээ шаардлагад үндэслэн хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлэх ажлуудыг бодлогын баримт бичгүүдэд тусган баталсан байна

1.1.1 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулсан “Ховд аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлэх дараах ажлуудыг төлөвлөн баталсан байна. Тухайлбал:

- Хүүхдийн эрхийг хамгаалах аливаа хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, хүнд хөдөлмөр эрхлэлтээс ангид байлгах үйл ажиллагааг дэмжих хувь хүн хуулийн этгээдтэй хамтран ажиллана,
- Хүүхдийн эмнэлгийг түшиглэн “Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн оношилгоо, зөвлөгөө өгөх төв”-ийг байгуулж шаардлагатай тоног төхөөрөмж, эмч, мэргэжилтнээр ханган тогтвортой ажиллуулах нөхцөлийг бүрдүүлнэ,
- Бүтэн өнчин хүүхдийн “Гэрэлт ирээдүй” хадгаламжийг үргэлжлүүлнэ,
- Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хохирогч хамгаалах түр хамгаалах байрыг MNS 60405:2019 стандартад нийцүүлж, тогтвортой үйл ажиллагааг хангана,
- Хүүхдийн ордны барилгад их засвар хийж, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлнэ,
- Хүүхдийн Баянбулаг зуслангийн үйл ажиллагааг сэргээж, MNS 5633:2019 стандартад нийцүүлэн ажиллана,
- Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг дэмжиж, эрсдэлт бүлгийн хүүхдүүдийн судалгааг гаргаж, даатгалд хамруулан, хамгаалах үйлчилгээ үзүүлнэ,

1.1.2 Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-т батлагдаж үүний дагуу хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бусад салбарын оролцоотойгоор бэхжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэхээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлж аймгийн хэмжээнд үндэсний хөтөлбөрт тусгагдсан дараах үр дүнтэй ажлуудыг үе шатайгаар хэрэгжүүлснээр хүүхэд хамгааллын үйлчилгээнд эерэг нөлөөлөл бий болж байна. Үүнд:

- Хүүхэд хамгааллын хамтарсан баг, бүх шатны засаг даргын дэргэдэх хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, гишүүдийг хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшүүлэх зорилгоор ХНХЯ-тай хамтран сургалт зохион байгуулснаар хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх хамтарсан багийн хууль, эрхзүйн мэдлэг дээшилсэн,
- Аймаг, сумдын ОНХС, ОНХО-аар 2019-2023 онд 105.1 сая төгрөгийн гэрэлтүүлэг, камержуулалт хийгдсэнээр хүүхдийн хамгаалалд ахиц гарсан,
- Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг тогтмолжуулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх заалтын хүрээнд 2022-2023 онуудад улс, орон нутгийн төсвийг хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж 280 хүүхдийг амруулсан,
- 2020 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамгаалах зорилгоор “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих” төслийн хүрээнд Японы Хүүхдийг ивээх сан, Сонсголгүйн боловсрол ТББ-ын дохионы хэлний багш нартай хамтран аймгийн ЕБС-ийн 60 гаруй багшийг дохионы хэлний сургагч багш бэлтгэх сургалтад хамруулан хүүхэдтэй ажиллах арга зүйгээр бэлтгэгдэж ном гарын авлагаар хангагдсан,
- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор бүтэн өнчин хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж олгохоор батлагдаж 2023 онд 61 өнчин хүүхэд 7.3 сая төгрөгийн хадгаламж нээн олгогдсон,
- “Монгол гэр бүл” хөтөлбөрийн хүрээнд аймгийн ЗДТГ, Бүсийн судалгаа мэдээллийн нийгмийн захиалга төв НҮТБ-тай хамтран “Ховд аймгийн хүүхэд хамгааллын нөхцөл байдал”-д судалгааны ажилд 7.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн,

1.1.3 Аймгийн ХГБХХГазар нь жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд орон нутгийн нөхцөл байдалтай уялдуулан хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх ажлуудыг төлөвлөн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг хийж биелэлтийг тооцон тайлагнасан байна.

Хүснэгт 1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний мэдээлэл

он	Нийт төлөвлөсөн арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь	Үүнээс: хүүхэд хамгааллын арга хэмжээний тоо	Хүүхэд хамгааллын арга хэмжээний биелэлт (хувь)	Нийт арга хэмжээнд хүүхэд хамгааллын талаар тусгасан арга хэмжээний эзлэх хувь
2019	28	99.4	12	11.9	42.9
2020	40	90.2	15	13.5	37.5
2021	28	92.2	12	11.1	42.9
2022	40	98.5	15	14.8	37.5
2023	38	95	14	13.3	36.8

Эх сурвалж нь: ХГБХХГ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан

1.1.4 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээнд хүүхэд хамгааллын талаар 2019 онд 12 арга хэмжээг тусгагдаж байсан бол 2023 онд 14 арга хэмжээг тусган хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн албан хаагчид дутагдалтай, хүний нөөцийн тогтвортой байдал хангагдаагүй байна

1.2.1 Аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын бүтэц орон тоог 2020 онд аймгийн Засаг даргын захирамжаар 24, 2022 онд Гэр бүлийн хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын А/63 дугаарт тушаалаар төрийн захиргааны 12, төрийн үйлчилгээний 13 нийт 35 орон тоотой баталсан байна.

Хүснэгт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Он	Хүний нөөцийн мэдээлэл				
	Батлагдсан орон тоо	Ажиллаж байгаа орон тоо	Үүнээс Нийгмийн ажилтан	Сэтгэл зүйч	Бусад
2019	19	19	3	1	15
2020	23	24	3	1	19
2021	24	24	3	1	20
2022	35	35	3	1	31
2023	35	35	3	1	31

Эх сурвалж нь: ХГБХХГ-аас ирүүлсэн судалгаа

1.2.2 Аймгийн ХГБХХГ нь жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг дээд шатны байгууллагаар батлуулан тайлагнаж, орон нутагт хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн, хэрэгжилтийг хангаж дараах үр дүн бүхий ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Хамтарсан багуудыг мэдээлэл арга зүйгээр хангасан,
- 2019 онд шилдэг хамтарсан багаар Цэцэг, шилдэг эцэг эхийн зөвлөлүүдийг шалгаруулж урамшуулсан нь баг, зөвлөлийн оролцооны идэвх дээшилсэн,
- Жаргалант суманд хамтарсан багийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж зорилтот бүлгийн иргэн, хүүхдийг хүлээн авах уулзалтын өрөө гарган тохижуулсан, сумын төсөвт эх үүсвэрийг тусгасан,
- Нийгмийн ажилтнуудад кейс шийдвэрлэлтээр урамшуулал олгодог болсон,

1.2.3 Сүүлийн 3 жилд байгууллагын дарга 3, нягтлан бодогч 4, хүүхэд хамгааллын ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, хөгжил оролцоо хариуцсан мэргэжилтэн, захиргаа хүний нөөц хариуцсан мэргэжилтнүүд 1-2 удаа солигдож өөрчлөгдсөнөөс үзэхэд хүүхэд хамгааллын асуудал хариуцсан төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдээгүй байна.

1.2.4 ХГБХХГ-ын 2024 оны байдлаар захиргаа хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтний орон тоонд албан хаагч ажиллуулаагүй, сул орон тоог зарлахтай холбоотой баримт, бичгүүдийг Төрийн албаны салбар зөвлөлд бүрэн хүргүүлээгүйгээс шийдвэрлэгдээгүй байна.

1.2.5 Аймаг, сум, багт хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий сумдын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн 17, багийн нийгмийн ажилтан 12, нийт 29 албан хаагчид аймгийн хэмжээнд ажиллаж байна.

1.2.6 Хүүхдэд хамгааллын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1¹-д сум, орон нутагт нийгмийн ажилтан ажиллуулж болох заалттай ч нийгмийн ажилтны үндсэн орон тоогүй, сумын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн уг ажлыг гүйцэтгэж байна.

1.2.7 Нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод нийгмийн ажилтны чиглэлээр их, дээд сургууль төгссөн төрийн албан хаагч ажиллахаар заасан ч орон нутагт мэргэжлийн боловсон хүчин дутагдалтайгаас Цэцэг, Мөст, Эрдэнэбүрэн сумын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтний ажлын байрыг мэргэжлийн бус албан хаагч ажлыг хавсран гүйцэтгэж байна.

1.2.8 Жаргалант сумын 12 багийн хэмжээнд мэргэжлийн нийгмийн ажилтан 75 хувийг эзэлж байгаа бол 25 хувь нь мэргэжлийн бус, Дарви, Зэрэг, Дуут, Буянт, Мөнххайрхан, Манхан, Чандмань сумдын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн нь багш, эрх зүйч, орчуулагч, мэргэжлийн албан хаагч гүйцэтгэж байгаа нь хөдөө орон нутагт мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна.

Хүүхэд хамгааллын талаарх мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй байна

1.2.10 Хүүхдийн эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.6², Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.8³-д тус тус заасны дагуу хүүхдийн эрх, хамгааллын талаар нэгдсэн статистик мэдээллийн сан бүрдүүлэн үйл ажиллагаандаа ашиглах зохицуулалтай ч 2022 онд статистик мэдээ гаргах аргачлалыг баталсан ч одоог хүртэл үйл ажиллагаанд бүрэн ашиглаагүйгээс мэдээллийн сан бүрдүүлэлт хангалтгүй байна.

1.2.11 ХГБХХГ-аас аудитад ирүүлсэн хүүхэд хамгааллын статистик мэдээ, байгууллагын үйл ажиллагааны тайлан дахь тоон мэдээллүүд хоорондоо зөрүүтэй, 2020-2021 оны статистик тоо мэдээлэл ирүүлээгүй, 2019-2023 оны статистик мэдээг нэгтгэн архивын нэгж үүсгээгүй байна.

Хүснэгт 3. Хүүхэд хамгааллын мэдээлэл

ҮЗҮҮЛЭЛТ		2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Нийт хүүхдийн тоо		35,262	36,138	36,736	36,790	36,617
Эрсдэлт бүлэгт байгаа хүүхдийн тоо		34	81	222	154	125
Эзлэх хувь		0.1	0.2	0.6	0.4	0.3
Эрсдэлт бүлэгт байгаа хүүхдийн тоо		34	81	222	154	125
Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо		1,039	810	1,188	1,039	1,964
Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо		1,200	1,399	1,666	1,257	1,164
Нийт хүүхдийн тоонд	хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	2.9	2.2	3.2	2.8	5.4
	урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	3.4	3.9	4.5	3.4	3.2
Эрсдэлт бүлэгт байгаа хүүхдийн эзлэх хувь	хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоонд	3.3	10.0	18.7	14.8	6.4
	урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоонд	2.8	5.8	13.3	12.3	10.7

Эх сурвалж нь: ХГБХХГ-аас ирүүлсэн судалгаа

1.2.12 Дээрх судалгаанаас үзэхэд 2019 онд аймгийн нийт хүүхдийн 0.1 хувь нь эрсдэлт бүлэгт амьдарч байсан бол 2021 онд 0.6 хувь болж өссөн, 2023 онд өмнөх оноос 0.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

¹ Орон нутгийн хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага нь нутгийн өөрөө удирдах байгууллагатай зөвшилцөн сум, баг, дүүрэг хороонд хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан ажиллуулна

² 14.1.6.хүүхдийн эрхийн талаар мэдээллийн сан бүрдүүлж, ашиглах;

³ 18.1.8.хууль сахиулах байгууллагатай хамтран хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн иргэн, хуулийн этгээд, хууль зөрчигч хүүхэд, гэрч, хохирогч хүүхдийн талаар мэдээллийн сан бүрдүүлж үйл ажиллагаандаа ашиглах;

1.2.13 Нийт хүүхдийн тоонд хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 2019 онд 2.9, 2023 онд 5.4 хувь болж 2.5 хувиар, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрагдалт 2019 оноос 0.2 хувиар буурсан байна.

1.2.14 Хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоонд эрсдэлт бүлэгт байгаа хүүхдийн эзлэх хувь 2022 оноос 8.4 хувиар, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрагдах хүүхдийн тоонд өмнөх оноос эрсдэлт бүлэгт байгаа хүүхдийн эзлэх хувь 1.6 хувиар тус тус буурчээ.

1.2.15 Сүүлийн 5 жилд хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагыг хүчирхийллийн төрлөөр нь авч үзвэл бие махбодын 140, бэлгийн хүчирхийлэлд 21, сэтгэл санаа 120, үл хайхрах байдалд 122, бусад хүчирхийлэлд 46 хүүхэд өртсөн, ирсэн дуудлагыг орчны ангиллаар авч үзвэл гэр бүл дэх 213, боловсролын салбарт 46, олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээний газарт 234 дуудлага иржээ.

Дүрслэл 1. Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага



1.2.16 Байгууллагын үйл ажиллагаанд able программыг ашиглан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хурдан морь унаач хүүхэд, хүүхдийн зусланд амарсан хүүхдийн талаарх мэдээллийг нэгтгэдэг ч унаач хүүхдийн тоо, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан тоо мэдээлэл хоорондоо зөрүүтэй байгаа нь нэг унаач хүүхэд хэд хэдэн төрлийн насны морийг давхардуулан унаж уралдуулдагтай холбоотой байна.

Хүснэгт 4. Хурдан морь унаач хүүхдийн талаарх мэдээлэл

	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Уралдааны тоо				98	32
Байгууллагын гүйцэтгэлийн тайланд тусгасан унаач хүүхдийн тоо	492	435	574	747	727
Able программд оруулсан унаач хүүхдийн тоо	46	46	237	111	220
Даатгалд хамруулсан хүүхдийн тоо				599	622

Эх сурвалж нь: Аймгийн ХГБХХГ -аас ирүүлсэн судалгаа, гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан

1.2.18 Нийгмийн ажилтны мэдээллийн сан буюу NAMS программ нь 2022 онд нийгмийн ажилтнууд нь үйлчилгээ үзүүлсэн кейс мэдээлэл, явц, шийдвэрлэлт, сум, багийн хамтарсан багийн гишүүдтэй холбоотой мэдээллийг оруулахад өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байсан 2023 оны 10 дугаар сард гэрээний хугацаа дуусаж хаагдсан байна.

БҮЛЭГ 2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ СУЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ХАНГАГДААГҮЙ БАЙНА

Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийн сан бүрдээгүйгээс статистик тоо мэдээг үнэн зөв нэгтгээгүй, төсвийн төлөвлөлтийг бодитой тооцоогүй байна


2.1.1 Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй гэж заасны дагуу ХГБХХГазар нь 2019-2023 оны төсвийн төслийн саналыг дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлжээ.

2.1.2 Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны 2019-2022 онд зарцуулах төсвийг төлөвлөхдөө харьяа дээд шатны байгууллагаас төсвийн төсөл боловсруулахад мөрдөх аргачлал, журам зааваргүй, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн эдийн засгийн үнийн өсөлттэй уялдуулан төлөвлөж байжээ.

2.1.3 Төсвийн төслийг боловсруулахдаа өмнөх оны хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулсан хүүхдийн тоо мэдээлэлд үндэслэн төлөвлөөгүй, 2019-2022 онуудад бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд нэгтгэн төлөвлөж ирсэн байна.

2.1.4 Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны зардлыг 2023 оноос хөтөлбөр, зориулалтаар тооцон 124.5 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2019 онтой харьцуулахад 4.8 дахин өссөн үзүүлэлттэй байна.

График 1. Хүүхэд хамгааллын 2019-2023 оны төсвийн төсөл, батлагдсан төсөв



Эх сурвалж нь: ХГБХХГ-ын 2019-2023 оны санхүүгийн тайлан

2.1.5 Өмнөх онуудад хүүхэд хамгааллын зардлыг бусдаар гүйцэтгүүлэх бараа үйлчилгээний зардалд нэгтгэн баталж, хүн ам, хүүхэд, өрхийн тоо, алслагдсан байдал, тохиолдлын тоо зэрэгт үндэслээгүйгээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглээгүй, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тулгуурлаагүй баталж ирсэн байна.

2.1.6 2022 оноос Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5⁴, 12.6⁵ дахь заалтын дагуу “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг баталж цахим мэдээллийн сан дахь тохиолдол/кейс/-ийн тоо, үзүүлсэн үйлчилгээний чанарын үнэлгээнд үндэслэн олгохоор журамласнаар 2024 оноос хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, зарцуулалтыг тодорхой тайлагнах нөхцөл бүрдсэн байна.

2.1.7 ХГБХХГ нь хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг 2021-2023 онуудад 100 хувь, 2019 онд 99.9 хувь, Ковид цар тахалтай холбоотой 2020 онд 78.9 хувийг зарцуулжээ.

⁴ 10.5.Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, үйлчилгээний зардлын норматив, санхүүжүүлэх аргачлалыг хүүхэд хамгааллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

⁵12.6 “Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн, хариу үйлчилгээг үзүүлсэн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүнд нэмэгдэл урамшуулал олгох бөгөөд уг журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална”


Хүснэгт 5. 2019-2023 онд хүүхэд хамгааллын үйлчилгээнд батлагдсан төсөв, гүйцэтгэл

он	Хүүхэд хамгааллын зардал		Төсвийн гүйцэтгэлийн хувь	Нэмэлт санхүүжилт	
	Төлөвлөгөө (сая.төг)	Гүйцэтгэл (сая.төг)		Орон нутгийн төсөв	Төсөл хөтөлбөр дээд шатны байгууллага
2019	76.9	76.8	99.9	62.1	27.4
2020	128.8	101.6	78.9	14.5	13.4
2021	93.6	93.6	100	17.5	54.4
2022	121.2	121.2	100	47.2	56.8
2023	198.5	198.5	100	5.3	36.4
Нийт	619.0	591.7	95.5	146.6	188.4

Эх сурвалж нь: ХГБХХГ-аас ирүүлсэн судалгаа,

2.1.8 Хүүхэд хамгааллын үйлчилгээнд 2019-2023 онуудад улсын төсвөөс 619.0 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 591.7 сая төгрөгийг зарцуулсан. Нэмэлт санхүүжилтийн дансаар хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл, ХНХЯам, ГБХЗЕГ, НҮБ-ийн төсөл, аймгийн ИТХ болон ЗДТГ, ОНХО, ОНХС, Засаг даргын нөөц хөрөнгөөс, Хөшөөт хөгжлийн сангаас нийт 335.0 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн зарцуулжээ.


2.1.9 Аймгийн ХГБХХГ-аас ирүүлсэн судалгаагаар 2019-2023 онуудад нийт 7,377 иргэд, хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлснээс 3,883 буюу 53 хувийг хамтарсан багийн, 1,849 буюу 25 хувийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд, үлдэх хувийг бусад нэр төрлийн үйлчилгээнд тус тус хамруулжээ. Дүрслэл 2 Хүүхэд хамгааллын үйлчилгээ



Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтын ил тод байдлыг бүрэн хангаагүй, төсвийн хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт сул, дотоод хяналт хэрэгжүүлээгүй, зарим хөрөнгө оруулалтын ажлууд үр дүнгүй хэрэгжсэн байна

2.2.1 Аймгийн ХГБХХГ-ын үйл ажиллагаанд 2019-2023 онуудад нийтдээ 3,525.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас төсвийн 17 хувь буюу 602.8 сая төгрөгийг хүүхэд хамгааллын үйлчилгээний зардалд зарцуулахаар батлагдсан нь 2019 оны төсөвтэй харьцуулахад 2023 онд 2.6 дахин өссөн байна.

Дүрслэл 3 ХГБХХГ-ын нийт батлагдсан болон хүүхэд хамгааллын зардлын төсөв



2.2.2 Сүүлийн 5 жилд хүүхэд хамгаалалд зарцуулсан зардлын 435.9 сая төгрөг буюу 73.7 хувийг хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд, 19.9 сая төгрөг буюу 3.4 хувийг нөхцөл

байдлын үнэлгээ хийх, 135.9 сая төгрөг буюу 23 хувийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулжээ

Дүрслэл 4 Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын зарцуулалт (5 жилийн нийт дүнгээр)



2.2.3 Хүүхэд хамгааллын үйлчилгээнд улсын болон орон нутгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байгууллагын дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.


- 2022 онд түр хамгаалах байрны үйл ажиллагаанд зориулж 2.5 сая төгрөгийн “хүлэмж” худалдан авахдаа ажил гүйлгээг давхардуулан гаргасан,
- Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа өрхүүдэд 5.8 сая төгрөгийн хүнсний багцыг хэн хэнд олгосон эсэх нь тодорхойгүй 2023 онд 1 дүгээр сард олгосон тайлан, зургийг 5,11 дүгээр саруудад олгосон хүүхдийн нэрс, ажлын тайлаг давхардуулан санхүүгийн баримтад хавсаргасан,

2.2.4 Төсвийн тухай хуульд заасны дагуу байгууллагын 2019-2023 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар Хүснэгт 6- д дурдсан зөрчлүүд илэрч зөрчлийг арилгаж ажилласан байна. Хүснэгт 6. СТА-ын дүгнэлт, алдаа, зөрчил

	Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Дүгнэлт
	тоо	дүн (сая.төг)	тоо	дүн (сая.төг)	тоо	дүн (сая.төг)	
2019 он			2	91.1	4	9.2	Хязгаарлалттай
2020 он	1	0.7	1	7.1	2	2.2	Хязгаарлалттай
2021 он					2	7.2	Зөрчилгүй
2022 он	1	1.1			3	7.2	Өөрчлөлтгүй
2023 он					1	6.5	Өөрчлөлтгүй

2.2.5 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянахад 2019-2023 онуудын таван сая төгрөгөөс дээш орлогын 345.7 сая төгрөгийн 30 ажил гүйлгээ, зарлагын 166.8 сая төгрөгийн 19 ажил гүйлгээг shilendans.gov.mn цахим сайтад ил тод мэдээлээгүй байна.

Дүрслэл 5. Шилэн дансны хуулийн хэрэгжилт



2.2.6 НҮБ-аас 2021-2023 онуудад 66.8 сая, ХЗДХЯ-ны “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслөөс 13.4 сая, Дезерит ОУБ-аас 14.4 сая, нийт 94.6 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж түр хамгаалах байраар үйлчлүүлэх иргэд амьдрах таатай орчин бүрдүүлэх, хариу үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхэд шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Хүснэгт 7. Хандивлагч байгууллагуудын мэдээлэл

Санхүүжүүлэгчийн нэр	2019	2020	2021	2022	2023
НҮБ	-	-	25.9	31.0	9.9
ХЗДХЯ		13.4			
Дезерит ОУБ		14.4			
Нийт	-	27.8	25.9	31.0	9.9

2.2.7 Японы “өвсний үндэс” хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 690.0 сая төгрөгөөр аймгийн ХГБХХГ-ын барилгын болон сантехникийн их засвар хийх ажил орон нутагт хэрэгжүүлснээр хүүхэд хамгааллын үйлчилгээ явуулах таатай орчин нөхцөл бүрдүүлжээ.

2.2.8 Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг Дэлхийн зөн ОУБ, Норвегийн тусламжийн байгууллагуудтай хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт, сурталчилгааг зохион байгуулан хамтран ажилласнаар хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хүний нөөцийг чадавхжуулах зэрэг үр дүн бий болжээ.

2.2.9 Хандивлагч байгууллагууд болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн зарим төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, захиалагч байгууллагаас дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- НҮБ, ХНХЯ-аас “Хамтдаа даван туулья” төслөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил бүрэн хийгдээгүй, гадна хаалга нь дотогшоо онгойдог байсныг эргүүлэн суурилуулсан, хүнсний материал хадгалах шкаф 4 хаалгатай хийлгэх байтал 3 хаалгатай хийгдсэн,
- Мөн төслөөс 10.0 сая төгрөгөөр ХБИ-ний орох, гарах хэсэг, хаалга хийх ажил гүйцэтгэхээр Шадар удам ХХК-тай гэрээ байгуулсан 1.0 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг дутуу гүйцэтгэсэн,
- Түр хамгаалах байрны ОО-ийн өрөөний суултуур, гар хатаагч, ХБИ-д зориулсан угаалтуур шүүгээний хамт нийт 2.1 сая төгрөгийн өртөг хийгдсэн эсэх нь тодорхой бус,
- Аймгийн ОНХО-аар Шадар удам ХХК-тай 14.0 сая төгрөгийн гэрээ байгуулан Баянбулаг зусланд хийгдсэн гадна тохижилтын ажлын гүйцэтгэлийг хянахад 1 бүр нь 2.0 сая төгрөгийн өртөгтэй 2ш сарагч хийгдээгүй, Зураг 1-д үзүүлсэн хүүхэд усанд орох байгууламжийг 0.4 сая төгрөгөөр хийсэн гэж хүлээн авч, холбогдох албан тушаалтнууд гарын үсэг зурж баталгаажуулсан,
- Мөн дээрх ажлын даалгаварт тусгасан 1600 метр 3.6 сая төгрөгийн төмөр торыг Ачлалт алаг хайрхан ХХК-аас давхардуулан худалдан авсан,
- Баянбулаг зуслангийн гадна тохижилтын ажил гүйцэтгэхээр Эх нутгийн уулс ХХК-тэй 2023.07.31-ны өдөр хүлээлгэн өгөх 80.0 сая төгрөгийн гэрээт ажлын даалгаварт тусгагдсан хуурай хог байгуулах, сарагч засварлах, дээвэр, цахилгаан монтаж камержуулалт засварлах ажлыг хийгээгүй, 20 гэрлийн шон суурилуулснаас 16 гэрлийн шон суурилуулсан ч 13 шон хугарч эвдэрсэн, ашиглах боломжгүй,
- Туяа бүлгийн дээвэр засварлахад 9.0 сая төгрөгийн ажлыг Шадар удам ХХК гүйцэтгэсэн ч удалгүй дээврээс ус гоожиж, 2024 онд дахин төсвөөс хөрөнгө зарцуулж дээврийн засвар дахин гүйцэтгэсэн,
- Хандиваар Дезерит ОУБ-аас 1.3 сая төгрөгийн өртөгтэй гал тогооны иж бүрэн тавилга өгөгдөж 2022 онд төсвийн хөрөнгөөр 950.0 мянган төгрөгөөр худалдан авсан бодитой 1 ширхэг гал тогооны тавилга оршин байгаа эсэх нь тодорхой бус, хөрөнгөд тавих хяналт хангалтгүй, тооллого тооцоог бүрэн хийдэггүй,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд “Түр хамгаалах байр”-ны барилга ашиглалтад оруулсан барилгын бүх давхрын хана цууралт үүссэн, өвлийн улиралд маш хүйтэн, цонх, ханаарай дулаан алдалт ихтэй, барилгын суулт өгөгдсөн,
- 2021 оны УТХО-аар 70.0 сая төгрөгөөр гадна тоглоомын талбай, хашааг “Тусгал төв ХХК”-тай гэрээ байгуулсан уг ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгсөн эсэх нь тодорхой бус,
- 2022-2023 онуудад хүүхэд хамгааллын үйлчилгээний сургалт зохион байгуулах, бусад үйл ажиллагааны зардлыг аж ахуйн нэгж байгууллага, хувь хүний харилцах дансанд шилжүүлэн байгууллагын удирдлага өөрийн дансаар 14.7 сая төгрөгийг буцаан авснаас 7.1 сая төгрөгийг ямар үйл ажиллагаанд зарцуулсан эсэх нь тодорхой бус тул төлүүлэх төлбөрийн акт тогтоох,
- Үлдэх 7.6 сая төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны баримт дутуу, худалдан авсан бараа материалыг орлогод аваагүй, зохион байгуулсан сургалтын баримтгүйгээр хүүхэд хамгааллын үйлчилгээний зардал гэж иргэн, ААН-үүдэд шилжүүлсэн байна. Уг зардлаас худалдан авсан 3 үйлдэлт принтерийг данс бүртгэлд тусгаагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй, бүртгэлээр тавих хяналт сул байгаад албан шаардлага өглөө.

Зураг 1. Хүүхэд усанд орох 3.0 сая төгрөгийн өртөг бүхий ажлын хэрэгжилт 2024.10.16



Аймгийн Хүүхдийн зөвлөл, хамтарсан баг, төрийн байгууллагуудын ажил уялдаагүйгээс хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлсэн ажил, санхүүжилтийн үр нөлөөг тодорхойлох боломжгүй, хувь хүний мэдээллийг нууцлах асуудал хангалтгүй байна

2.2.10 Хүүхдийн эрх, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу аймгийн Засаг даргын 2022 оны А/234 дүгээр захирамжаар “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн бүрэлдэхүүн, нарийн бичгийн дарга, гишүүдийг томилж, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, зөвлөлийн ажиллах дүрэм, гишүүдийн ажлын албаны эрх үүрэг, ажлын чиг үүргийг тодорхойлсон ч аймгийн хүүхдийн төлөө зөвлөл нь чиг үүрэгээ хэрэгжүүлэн ажиллаагүй, салбар хоорондын чиг үүргийг биелэлтийг тайлагнаагүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд 2 удаа хуралдснаар тусгасан боловч зөвлөлийн хуралдааны тэмдэглэл гаргасан шийдвэргүй, зөвлөлийн хэрэгжүүлсэн ажлын тайлан бүрэн бус байна.

2.2.11 Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүдийн чиг үүргийг тодорхой заасан ч салбар хоорондын ажлын уялдаа хангалтгүйгээс тухайн онуудад хийх ажлын төлөвлөгөө боловсруулсан болон хэрэгжүүлэн ажил, хэлэлцсэн болон, шийдвэрлэсэн асуудал, ажлын тайлан мэдээгүй байна.

2.2.12 Хүүхэд хамгааллын чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх, сайжруулах, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэн таслан зогсоох, хамгаалах хариу үйлчилгээ үзүүлэх, зорилгоор Жаргалант сумын 12 баг, 17 сум, ЕБС, СӨБ-уудад “Хамтарсан баг”-ийг сум байгууллагын Засаг дарга болон холбогдох албан тушаалтан, мэргэжилтэнг оролцуулан ажиллуулж байна.

2.2.13 Хамтарсан баг нь хүүхэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хамгаалах хариу үйлдэл үзүүлэх чиг үүрэг бүхий орон нутгийн удирдлага мэргэжилтнүүдээс бүрдсэн баг хэдий ч мэргэжлийн үйлчилгээний стандартын дагуу ажиллаж байгааг нотлох баримт материалууд дутмаг, зарим хамтарсан багууд тухайн онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажилласан ч үр дүнг бодитой тооцоогүй байна.

2.2.14 Салбар дундын хамтын ажиллагааг зохицуулахын тулд салбар бүрийн оролцоо, чиг үүргийг захирамжид нарийн тодорхойлон заасан ч, салбар бүрд хүүхэд хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн ажилладаггүй, салбарын хүүхэд хамгааллын чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд шаардлагатай төсөв, хөрөнгийг жил бүр салбарын төсөвт эх үүсвэр батлаагүйгээс хүүхэд хамгааллын тогтолцоонд оролцогч тал бүр үүрэг хариуцлага бүрэн хангагдаагүй, үйл ажиллагаа хамтран явуулах боломж бүрдээгүй байна.

2.2.15 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2019-2023 онуудад хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэн зөвлөмж хүргүүлэн, 2019 онд 4 суманд тус бүр 1.0 сая төгрөгөөр урамшуулсан байна.

2.2.16 “Байгууллагын нууцын тухай” хуулийн 5 дугаар зүйлд⁶-д тухайн байгууллагын нууцыг хамгаалах журмыг өөрийн байгууллагын онцлогт нийцүүлэн тогтоохоор заасан ч ХГБХХГазар нь байгууллагын нууцыг хамгаалах талаар журам боловсруулаагүй хуулийн холбогдох заалтыг мөрдөөгүй байна.

2.2.17 Хүүхэд хамгааллын үйлчилгээний зарлагын ажил гүйлгээний санхүүгийн анхан шатны баримтад төсвийн шууд захирагчийн тушаал, хүүхэд хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтний тайланд хүүхдийн овог нэр, регистрийн дугаар, хүүхэд, иргэний нэр, иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсарган архивын нэгж үүсгэсэн, аймгийн ИТХ-ын болон Засаг даргын захирамжаар өмгөөлөгчийн зардал гаргах шийдвэрт хүүхдийн овог нэр, регистрийн дугаар бичиж гаргасан, тухайн захирамж шийдвэрүүдийг khovd.gov.mn цахим сайтад ил тод

⁶ 1.Байгууллагын нууц нь тухайн байгууллагын хамгаалалтад байна. Байгууллага нь нууцаа хамгаалах журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрөө тогтоож мөрдөнө.

байршуулж зэрэг нь "Хүний хувийн мэдээлэл хамгаалалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11⁷-д заасан заалттай нийцэхгүй байна.

2.2.18 ХГБХХГ-ын дэргэдэх түр хамгаалах байранд гаднын хүн нэвтрэхэд урьдчилан зөвшөөрөл өгдөггүй, нууцын батлагаа гаргуулаагүй, ХНХЯамны сайдын 2020 оны А/150 дугаар тушаалаар "түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлын тооцох" журам батлагдсан, нэг хүнд ногдох хувьсах зардлын дундаж норматив 60,680 төгрөг байгаа нь эдийн засгийн инфляцтай уялдаагүй, журмын 5.1⁸-д зааснаар тарифыг шинэчлээгүйгээс үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байна.

2.2.19 Аймгийн ХГБХХГ-ын 2019-2023 онуудын байгууллагын үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, албан хаагчдын тухайн онуудад хэрэгжүүлсэн үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, бичмэл тайлан, статистик мэдээг он бүрээр нь нэгтгэсэн архивын нэгж үүсгээгүй, эмх цэгцгүй, байгууллагын тухайн онд хөтлөгдөх хөтлөх нэрийн жагсаалтыг гаргаж байгууллагын дэргэдэх ББНШК-ын хурлаар хэлэлцүүлэн батлаагүйгээс үзэхэд хариуцсан албан хаагч нь ажлын байрны тодорхойлолт заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.


2.2.20 Урьдчилан сэргийлэх үйлчилгээний 2023 оны зардлыг ХНХЯ-ны сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар хамтарсан тушаалаар "хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив" тооцох аргачлалаар тооцоход 55.6 сая төгрөгийн төсөв шаардлагатай байна.

Хүснэгт 8		Зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардал								/мян.төг/	
Эрсдэл ийн зэрэг өндөр хүүхдийн н тоо	Аргач лал тооц он өртөг	Хүүхдэд чиглэсэн хөгжил сургалт нөлөөллийн ажил	Нийт хүн амын тоо	Аргач лал тооц он өртөг	Олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн зардал	Хамта рсан багийн тоо	Аргачла л тооцсон өртөг	Боловсо н хүчин чадавхж уулах за рдал	Нийт дүн	Батлагд сан төсөв	Зөрүү
154	7.5	1,155	90671	0.375	34001.6	29	705.5	20,460	55,617	43,189	12,428

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны урьдчилан сэргийлэх үйлчилгээнд зардал 43.2 сая төгрөг батлагдаж 12.4 сая төгрөгөөр дутуу санхүүжилт олгогдсон нь эрсдэлтэй нөхцөлд байгаа нь хүүхдийг эрсдэлт нөхцөлөөс урьдчилан, сэргийлэх эрхийг хамгаалах, сургалт, нөлөөллийн ажил, салбар дундын байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах, хамтарсан багийн сургалт болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэхэд эх үүсвэр хүрэлцэхгүй байх нөхцөл

2.2.21 Урьдчилан сэргийлэх, үйлчилгээний зардалд 2023 онд нийт 43.2 сая төгрөгийг зарцуулснаас сургалтын хэрэглэгдэхүүн, цайны зардалд 14.9, томилолтод 3.3, сургалтын үйл ажиллагаанд 16.4, сургагч багшийн зардалд 8.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан үзүүлэлттэй байна. Дүрслэл 6 Урьдчилан сэргийлэх үйлчилгээний 2023 оны зарцуулалт

2.2.22 Хүүхэд хамгааллын чиглэлээр батлагдсан төсвийг урьдчилан сэргийлэх арга хэмжээний үйл ажиллагаанд буюу эрсдэлт нөхцөлд амьдарч хүүхэд, гэр бүлийн гишүүдэд сургалт зохин байгуулах удирдамж, төсөв боловсруулан цайны зардал, үдийн хоол, бал, тэмдэглэлийн дэвтэр зэрэгт зарцуулсан ч оролцогчдын бүртгэл дутуу, сургалтын өмнөх болон дараах үнэлгээ хийгдээгүй, сургалтаас бий болсон үр дүнг нэгтгэн тооцоогүй байна.



⁷ 4.1.11. "хүний хувийн мэдээлэл" гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг

⁸ Энэ журмын хавсралтаар баталсан нэг хүнд нэг өдөр ногдох зардлын дундаж нормативыг гурван жил тутамд нэг удаа шинэчилнэ

БҮЛЭГ 3: ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ХЯНАЛТЫГ ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлсэн хяналт сул, өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг тооцдоггүйгээс бий болсон үр нөлөө тодорхойгүй байна

3.1.1 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1⁹, 21.2¹⁰ -д хүүхдийн төлөө зөвлөл бодлогын хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэн, холбогдох байгууллагуудад шийдвэр зөвлөмж хүргүүлэхээр хуульчилсан ч өмнөх онуудад хэлэлцсэн асуудал, хэрэгжүүлсэн хяналтын талаарх мэдээлэл аудитад ирүүлсэнгүй.

3.1.2 Харин 2024 оныг “Хүүхдэд ээлтэй хүний хөгжлийн дэмжих жил” болгон зарлаж, хүүхдийн төлөө зөвлөлийг 2 удаа хуралдуулан салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээ, зөвлөлийн 2024-2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны санал төлөвлөгөөг боловсруулан 9 асуудлыг хэлэлцүүлж хүүхэд хамгааллын үйлчилгээнд 1,379.2 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг үе шаттайгаар орон нутгийн төсөвт тусгуулахаар шийдвэрлэсэн байна.

3.1.3 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3¹¹-д заасны дагуу жил бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дараах ажлуудыг хэрэгжүүлсэн ч хэрэгжүүлсэн хяналтаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг тооцоогүйгээс, хяналтын үр нөлөөг тодорхойлох боломжгүй байна. Үүнд:

- 2022, 2023 онуудад хүүхдийн төлөө зөвлөл, хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх ажлыг Жаргалант сумын 12 баг, Алтай, Булган, Үенч сумдын хамтарсан баг, хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөгөө арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулж дүгнэлт зөвлөмж хүргүүлсэн,
- 2019 онд Буянт, Мянгад, Ховд, Эрдэнэбүрэн сумдад хяналт хэрэгжүүлсэн,
- 2019 онд аймгийн 17 сумын хүүхдийн элч нарын үйлчилгээ, үйл ажиллагааны чанар, хүртээмжийн талаар санал, үнэлгээ, дүгнэлт өгөх зорилгоор хяналт-шинжилгээ 5 үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийж 6 дүгнэлт зөвлөмж гарч холбогдох газарт хүргүүлсэн,
- Аймгийн хүүдийн төлөө зөвлөлийн хяналт шинжилгээ үнэлгээг 6 чиглэлийн дагуу хийж гарсан зөрчлийн дагуу дүгнэлт зөвлөмжийг хүргүүлсэн ч биелэлтүүдийг тооцоогүй,

3.1.2 Мөн байгууллагын дотоод үйл ажиллагаанд агентлагийн даргын 2019 оны А/8 дугаар тушаалаар батлагдсан “Гэр бүл, хүүхэд залуучуудын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” аргачлалаар түр хамгаалах байрны үйл ажиллагаа, архив бичиг хэрэг хөтлөлт, стандарт, гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн журмын хэрэгжилт зэргийг хамруулан хяналт үнэлгээг хэрэгжүүлсэн ч аудитаар архив бичиг хэргийн хөтлөлт хангалтгүй, түр хамгаалах байрны өдөр тутам хөтлөх маягтуудыг хөтлөөгүй зэргээс үзэхэд хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

3.1.3 Хүүхдийн эрхийн талаар олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмжийн талаар орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллагад ирүүлсэн баримт бичиггүй байна.

3.1.4 Аймгийн ХГБХХГ нь Дэлхийн Зөн ОУБ, Японы Хүүхдийг ивээх сан, Норвегийн тусламжийн байгууллагууд хүүхэд хамгаалал, хүүхдийн хөгжил чиглэлээр өргөн хүрээнд үйл ажиллагааг хамтран зохион байгуулдаг бөгөөд энэ талаар орон нутгийн байгууллагад хэрэгжүүлсэн арга хэмжээ, хөтөлбөрийн үр дүнг нэгтгэн тооцон баталгаажуулсан баримт материалгүй байна.

⁹ 21.1. Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина

¹⁰ 21.2. Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл жил бүрийн 3 дугаар улиралд багтаан хүүхэд хамгааллын тайлан гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төрийн захиргааны байгууллагад чиглэл, нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох бусад байгууллагад зөвлөмж өгч, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий оролцогч талуудад санал оруулна.

¹¹ 18.2.3. Хүүхдийн эрхийн тухай хууль болон энэ хуулийн хэрэгжилтэд гурван жил тутамд нэгээс доошгүй удаа анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;

3.1.5 Жил бүр аймгийн ЗДТГ-ын хяналт үнэлгээний хэлтсээс Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын бодлогын баримт бичгүүдэд хяналт үнэлгээг хийгдэж, дүгнэлт зөвлөмжүүдийг хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажиллаж байгаа ч хяналтын үр нөлөө бий болоогүй байна.

3.1.6 Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар хэрэгжүүлэх тусгайлсан дэд хөтөлбөр батлаагүй байна.

- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.12-д “Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүд, эцэг, эхийг дэмжих “Монгол гэр бүл” хөтөлбөр баталсан,
- Аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 29 дэд хөтөлбөрүүд баталсан ч хүүхэд хамгааллын чиглэлээр тусгайлан баталсан хөтөлбөргүй,
- ОНХС-гаас хүүхэд хамгааллын зардалд Дарви сум 2.0, Дуут сум 1.2 сая төгрөг баталсан ч зарцуулаагүй,


3.1.7 Аймгийн Засаг даргын А/234 дугаартай захирамжаар хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүн СТСХ-ийн даргын ажиллах чиг үүрэгт ОНХС-ийн нийт хөрөнгийн 10-аас доошгүй хувийг хүүхдэд зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавих, хүүхэд хамгааллыг сайжруулахад хөрөнгийг төвлөрүүлэхээр заасан ч хэрэгжилт хангагдаагүй байна.

Аймгийн хэмжээнд гарсан хүүхэд хамгааллын зөрчлийн дийлэнх хувийг гэр бүлийн орчинд үүссэн байна

3.2.1 Хүүхдийн тусламжийн 108 утсанд сүүлийн 5 жилд нийт 513 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн, ирсэн дуудлага мэдээллийг орчноор нь авч үзвэл 234 дуудлага нь 45.6 хувь нь гэр бүлийн орчинтой холбоотой ирсэн байна.

3.2.2 Гэр бүлийн орчинд үйлдэгдэж буй хүчирхийллийг бууруулах, эцэг эх асран хамгаалагчид гэр бүлийн боловсрол олгох, хандлага зан үйлд нь нөлөөлөх, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр 2019 онд 129 төрлийн арга хэмжээнд 21000 мянган иргэнийг, 2020 онд 2 төрлийн арга хэмжээнд 2610 иргэн, 2021 онд 4 төрлийг арга хэмжээнд 2568 иргэн, 2022 онд 15 төрлийн арга хэмжээнд 17035 иргэн, 2023 онд 37 төрлийн арга хэмжээнд 6190 иргэнийг тус тус хамруулсан байна. Дүрслэл 7 Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага

3.2.3 Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” 03 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, Ховд аймагт үйл ажиллагаа явуулж буй байгууллага аж ахуй нэгжийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл” байгуулах, байгууллагынхаа онцлогт тохирсон “Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг”-ийг боловсруулан хэрэгжүүлэх чиглэлийг хүргүүлж, 2019 онд 85 эцэг эхийн зөвлөл байгуулагдсан бол 2023 онд 108 эцэг эхийн зөвлөл байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.



3.2.4 Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигтэй 35 байгууллага байсан бол 2023 онд 90 байгууллага болж өссөн, хүүхдийн өрөөтэй 10 байгууллага байгаа нь хуулийн хэрэгжилт хангагдаж, тухайн байгууллагын ажлын бүтээмжид эерэг нөлөөлөл үзүүлж байна.

3.2.5 Эцэг эх, асран хамгаалагчдад чиглэсэн сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулснаар гэр бүлийн орчинд үйлдэгдэж буй хүчирхийллийн дуудлага, мэдээллийн илрүүлэлт сайжирсан нь Хүүхдийн тусламжийн утсанд 2019 онд гэр бүлд орчинд үйлдэгдсэн кейс бүртгэгдэж, 2023 онд бүртгэгдсэн нийт гомдол мэдээллийн 64.7 хувь нь гэр бүлийн орчинд үйлдэгдсэн байна.

3.2.6 Байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл” –ийг жилд 1-2 удаа удирдлага арга зүйгээр хангаж, тэднээр дамжуулан тухайн байгууллага, аж ахуй нэгжид ажиллаж буй эцэг эхчүүд, түүний хүүхдүүдийн эрхийг хангахад чиглэсэн мэдээллийн хүртээмж нэмэгдсэн.

Боловсрол салбарт мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдсанаар сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээнд эерэг нөлөөлөл бий болж, хүүхэд хамгааллын статистик мэдээг нэгтгэн гаргадаг үр дүн бий болжээ


3.2.7 Боловсролын салбарт хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх бодлогыг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 14 дүгээр зүйлийн 14.1.2¹², 14.1.5¹³-д журамласны дагуу Боловсрол соёл спортын сайдын 2018 оны А/476 тогтоолоор “ЕБС-ийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого” батлагдаж эрх зүйн зохицуулалтуудыг хуульчилж сургууль, дотуур байрны орчинд сурагчдыг аливаа болзошгүй эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх хамгаалах, мэдээлэл, таамаглалыг хүлээн авах, хүүхэд авах, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, хяналт үнэлгээний нэгдсэн тогтолцоо бий болжээ.

3.2.8 Аймгийн хэмжээнд ЕБС-уудад хүүхэд хамгааллын баг 354 гишүүнтэй үйл ажиллагааг явуулж, салбарын хүүхэд хамгааллын тайланд сургуулийн орчин дахь суралцагчийн эрсдэлийн үнэлгээ, ирсэн дуудлага мэдээллийн тоо, хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр, үе тэнгийн дээрэлхэл, шуурхай тусламж, нөхөн сэргээх үйлчилгээ зэрэг асуумжаар нэгтгэдэг байна.

3.2.9 Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны А/172 дугаар тушаалаар “Хүүхдийн эрх, хамгааллын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал” баталж аргачлалын дагуу боловсролын удирдлагын мэдээллийн системд холбогдох заалтуудыг тусган салбарын хүүхэд хамгааллын статистик мэдээг нэгтгэн харьяа дээд шатны байгууллагад хүргүүлдэг болсноор сургуулийн орчин дахь эрсдэлийн үнэлгээнд нийт 19120 суралцагчийг хамрагдсанаас 357 өндөр, 969 дунд, 4591 хүүхэд бага, 13203 хүүхэд огт эрсдэлгүй, эрсдэлтэй гэж үнэлэгджээ.

3.2.10 Шуурхай тусламжийн үйлчилгээнд хамрагдсан суралцагчдаас бусад салбарын хамгаалах үйлчилгээнд 101 хүүхдийг холбон зуучилснаас хүүхдийн тусламжийн 108 утсанд 18, эрүүл мэндийн байгууллагад 27, хамтарсан багт 31, Цагдаагийн газарт 20, бусад байгууллагад 18 хүүхдийг тус тус холбон зуучлах үйлчилгээнд хамруулсан байна.

Дүрслэл 8 Боловсролын салбарын хүүхэд хамгааллын мэдээлэл



Эх сурвалж. Аймгийн БШУГ-ын 2023-2024 оны хичээлийн жилийн статистик

3.2.11 Дээрх мэдээллүүдээс харахад хүүхэд хамгааллын үйлчилгээний статистик тоо мэдээг дэлгэрэнгүй нэгтгэдэг болж мэдээллийн технологийн системийн хөгжүүлэлт сайжирч,

¹² 14.1.2.боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

¹³ “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам”

нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн орон тоог бий болгосноор сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээнд эерэг нөлөөлөл үзүүлж байна.

ХГБХХГ нь эрүүл мэнд, соёл, спорт, хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагуудтай хүүхэд хамгааллын чиглэлээр үр нөлөөтэй хамтран ажиллах шаардлагатай байна

3.2.12 Хүүхдэд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, таатай орчин бүрдүүлэх зорилгоор хүүхдийн тасгийн үйл ажиллагааг өргөтгөн УТХО-аар 2022 онд “Хүүхдийн клиник”-ийн 5.8 тэрбум төгрөгийн өртөгтэй барилга ашиглалтад орсон, “Өсвөр үеийн кабинет” ажиллаж эхэлсэн, Норвегийн тусламжийн байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн кабинетыг байгуулсан зэрэг үр дүнтэй ажлууд хийгдсэнээр хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэг дороос авах боломж бүрдсэн.

3.2.13 Эрүүл мэндийн байгууллага эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг холбогдох хуульд заасны дагуу харьяалагдаж буй төрийн захиргааны байгууллагуудад мэдээллийг хүргүүлэн ажиллаж эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж буй эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо 9 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 9. Эрүүл мэндийн салбарын мэдээлэл

Эрүүл мэндийн үйлчилгээний төрөл	2019	2020	2021	2022	2023
Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчид мэдээлсэн	1		2	8	15
Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрсөн этгээдэд мэдээлсэн			2	3	11
Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн хүүхэд	2	1	2	9	18

3.2.14 Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхдэд зориулсан мэдээ, мэдээллийг хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан олон нийтэд мэдээлэхээр заасны дагуу орон нутагт үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулан 2019-2023 онуудад хүүхэд хамгааллын зардлаас 17.4 сая төгрөгийг зарцуулж, гэрээнд хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар нарийвчилсан заалтууд тусгагдаагүй байна.

3.2.15 Аймгийн ГБХХЗГ орон нутгийн телевиз, цахим сайт болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийг олон нийтэд ил тод, шуурхай хүргэх зорилгоор гэрээ байгуулан ажилласан ч орон нутагт хүүхдийн эрхийг зөрчсөн тохиолдол буурахгүй байна.

3.2.16 Хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх постер, зөвлөмж, зөвлөгөө, бусад мэдээ мэдээллийг байгууллагын пэйж хуудас, 17 сумын цахим хуудас, аймгийн нэгдсэн 5 цахим группээр нийт давхардсан тоогоор 73199 хүнд хүргэснээр байгууллагын пэйж хуудсанд хандах хандалтын тоо 2 дахин өсжээ.

3.2.17 Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа цахим тоглоомын газруудад ХГБХХГ, Цагдаагийн газар, БШУГ, Мэргэжлийн хяналтын газруудад хяналт шалгалт хийгдэж алдаа, зөрчил илэрсэн газруудад зөрчил арилгах талаар мэдэгдэл хүргүүлэн аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд нэгдсэн сургалт зохион байгуулан шаардлага хангаагүй цахим тоглоомын газруудад холбогдох хууль тогтоомжийн үйл ажиллагааг зогсоох, хаах арга хэмжээг авч ажиллажээ.

3.2.18 Өмнөх онуудад олон нийтийн арга хэмжээнд хүүхдийг хэрхэн оролцуулах, эрхийг хамгаалах талаарх нарийвчилсан зохицуулалтгүй, 2022 оноос ГБЗХГазар, Соёл урлагийн газрын даргын А/242, А/76 дугаар тушаалаар батлагдсанаар оролцогч талуудын үүрэг

оролцоог журамласан байхад аймгийн ХГБХХГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд олон нийтийн арга хэмжээ, соёл спортын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тусгасан заалт тодорхойгүй байна.

3.2.19 Дээрх журмын 3.5.7 дахь заалтын дагуу хурдан морь унаач хүүхэд, эцэг эх, уяачтай гуравласан гэрээ байгуулан даатгалд хамруулан ажиллаж хэвшсэн ч элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөд хичээл болон хичээлийн тоог хязгаарлах эсвэл албадлага үзүүлэх зэргээр хүүхдийн эрхийг зөрчихгүй байх гэсэн заалт амьдрал дээр түгээмэл гарч байна.

3.2.20 Гамшгийн тухай хуулиар үүрэг хүлээсэн төрийн болон олон улсын байгууллагууд гамшиг, онцгой нөхцөл байдлын үед шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэн хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлж ирсэн байна. Үүнд:

- 2020 онд аймгийн 17 сумын хамтарсан багтай хамтран гамшиг онцгой байдлын үед зорилтот бүлгийн өрхүүдэд 715 өрхийг түргэвчилсэн үнэлгээнд хамруулан хүүхдийн аюулгүй байдал бүрэн хангагдаагүй айл өрхүүдэд шаардлагатай үйлчилгээг үзүүлэн, 110 өрхөд хүнсний багц, 17 өрхийн 33 хүүхдэд өвлийн дулаан хувцас, зорилтот бүлгийн 800 хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй 200 хүүхэд, онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчийн 1500 хүүхдэд маск, гар ариутгагч, дархлаажуулалтын багцыг хүргэх ажлыг зохион байгуулсан,
- Ковид-19 цар тахлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх, түр журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд цар тахлаар 7961 тохиолдол бүртгэгдсэнээс өвчилсөн иргэдийн 20.3 хувь буюу 1620 хүүхэд өвчилж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг, мэргэжлийн байгууллагууд үзүүлсэн,
- 2021 онд гамшиг онцгой нөхцөл байдлын үед ажиллах мэргэжлийн ангийг байгууллагын даргын А/05 дугаар тушаалаар 12 хүний бүрэлдэхүүнтэй баталж, хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан цар тахлын үед эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээг 320 гаруй өрхөд хийж 125 өрхөд хүнсний багц, 253 хүүхдэд хөгжлийн болон дархлаажуулалтын багц өгч, 466 иргэн, хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн,
- 2023 онд хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн үйл ажиллагааг эрчимжүүлж гамшиг, онцгой нөхцөл байдлын үед бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэн тайлагнах зорилтын хүрээнд 5 төрлийн үйл ажиллагаа явуулж 210 өрхийг хамруулсан,
- ОУБайгууллага, Японы хүүхдийг ивээх сангаас 2022-2023 оны өвөл зуд болж, өвөлжилт хүндэрсэн сумдын малчид болон малчдын хүүхдүүдэд малын тэжээл, бэлэн мөнгөний тусламж үзүүлэх зэргийг ажлуудыг хамтран зохион байгуулсан,

Хүүхдийн эрхийн олон улсын конвенцод нэгдсэн үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна

3.3.1 Хүүхдийн эрхийн олон улсын конвенцод заасны дагуу Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайланд өгөгдсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийг цахимжуулсан, унаач хүүхдүүдийн эрхийг хамгаалсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх байртай болсон зэрэг үр дүн бүхий ажлууд орон нутагт хэрэгжсэн байна. Тухайлбал:

- Аймгийн засаг даргын 2021 оны хөтөлбөрт тусгасны дагуу “Хүүхдэд ээлтэй орон нутаг, санаачилга” арга хэмжээний хүрээнд Норвегийн тусламжийн байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих” төсөл хэрэгжиж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-ийн барилга баригдаж 2023 оны 3 сард ашиглалтад орсноор давхардсан тоогоор 1500 орчим иргэдэд үйлчилгээ үзүүлсэн,
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгахын тулд Засгийн газраас гаргасан тогтоолыг орон нутагт хэрэгжүүлэн ажиллах зорилгоор хурдан морь унаач хүүхдүүдийг уралдаан оруулахдаа эцэг эх, асран хамгаалагчдаас зөвшөөрөл авах, аюулгүй байдал, гэмтэл бэртлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай хувцас хэрэгсэл, даатгалд хамруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулан хяналт хэрэгжүүлсэн,
- Хүүхдийн эрхийн мэдээллийн санг бүрдүүлэх, тайлагнах, мэдээллээр хангах талаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу орон нутгийн байгууллага нь able программыг зөвхөн эрсдэлт нөхцөл байгаа хүүхэд, хурдан морь унаач хүүхэд, хүүхдийн зусланд амарсан хүүхдийн мэдээллийг оруулан нэгтгэдэг болсон,

3.3.2 НҮБ-ын хүүхдийн эрхий тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын Ү тайланд өгөгдсөн дүгнэлт, зөвлөмжийн дагуу Засгийн газрын 2019 оны 57 дугаар

тогтоолын 1¹⁴ дэх заалтыг зөрчин Жаргалант, Алтай, Цэцэг, Булган, Мөст, Мөнххайрхан сумдад хурдан морины үсэргээ, сунгаа зохион байгуулсан 5 зөрчилд илрүүлэн 7 иргэнийг 3.5 сая төгрөгөөр торгууль ногдуулсан, аймаг, орон нутагт хэрэгжүүлэн ажиллаж, орон нутгийн төсвөөс 9.8 сая төгрөгийг хурдан морь унаач хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангахад олгогджээ.

- 2019, 2021 онуудад хурдан морь унаач хүүхдийн хамгаалах хэрэгсэл 80 гаруй хүүхдүүдэд олгож хариуцсан мэргэжилтэн болон бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай тооцоо нийлж үлдээдлийг баталгаажуулаагүй,

3.3.3 Аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 29 шашин сүм хийдийн байгууллага, үүнээс Жаргалант сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 14 сүм хийдэд 11-14 насны 3 хүүхэд сургуульд завсардсан шавилан сууж байна.

108 утсанд ирсэн дуудлага, мэдээллийн дагуу хариу арга хэмжээг авч ажиллаж байгаа ч хамтарсан багийн гишүүдийн ажлын чиг үүргийн хэрэгжилт сул байна

3.3.4 Аймагт 2019-2023 онд 108 утсанд 2019 онд 51 дуудлага мэдээлэл ирдэг байсан бол 2023 онд 3 дахин өссөн, аймгийн ХГБХХГ-ын 108 утсанд дуудлага өгөхөөс гадна аман болон бичгээр дуудлага мэдээллийг 2019 онд 10 байсан бол 2023 онд 85 дуудлага мэдээлэл ирсэн байна.

	Хүснэгт 10		Хүүхдийн тусламжийн 108 утасны мэдээлэл		
төрөл	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Нийт дуудлагын тоо	51	95	97	117	153
Аман болон бичгээр ирсэн дуудлага, мэдээллийн тоо	10	24	63	65	85
Хаагдсан дуудлагын тоо	51	93	97	95	141
Хяналтад байгаа дуудлагын тоо		2		22	6
Эзэн тодорхой бус дуудлагын тоо			7	12	6
Дуудлагын шийдвэрлэлт	100	97.9	85	81.2	92.2

Эх сурвалж нь: ХГБХХГ-ын үйл ажиллагааны тайлан

3.3.5 Хүүхдийн тусламжийн утсанд ирсэн дуудлага мэдээллийг шилжүүлэн 72 цагийн дотор үйлчилгээг үзүүлэн хамтарсан баг нь үнэлгээг хийж программд цаг тухайд нь оруулдаггүй, дуудлага мэдээллийн шийдвэрлэх талаар сумдын хамтарсан баг, нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэнд мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгөн ажилласан ч дараах бэрхшээлтэй асуудлууд байсаар байна. Үүнд:

- Хүүхэд хамгааллын чиглэлийн албан хаагчийн ажлын ачаалал их, сум, багийн бүх ажилд дайчлагддаг,
- Сум, багийн дарга нарын ажлыг чиг үүрэг, хариуцлагыг ойлгуулах, хууль тогтоомжоор олгогдсон эрх үүргийг бүрэн танилцуулах,
- Сум, багийн дарга нарыг улс төрөөс хамааралтай ойр ойрхон солигддог,
- Хуульд хамтарсан багийн гишүүд орон тооны бус учраас кейс дуудлага мэдээлэл дээр багаараа бүрэн очиж үнэлгээ хийх боломжгүй байгаа нь сум, багийн түвшинд эмч алсын дуудлагад явсан, үйлчлүүлэгч ихтэй тохиолдолд ирэх боломж бүрддэггүй зэрэг нөхцөл үүсдэг
- Байгууллагын статистик мэдээнд аман болон бичгээр ирсэн дуудлагыг бүрэн нэгтгээгүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд тусгасан,

3.3.6 Хүүхэд хамгааллын талаарх мэдээ мэдээллийг able программын бусад хэсэгт эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хурдан морь уяач хүүхэд, хүүхдийн зусланд амарсан хүүхдийн тоон мэдээллийг оруулан өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

3.3.7 Able программд сум, багийн нийгмийн ажилтан, нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн нэвтрэх эрхгүйгээс мэдээллийг аймгийн хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтэнд хүргүүлж нэвтрэх эрхтэй 6 мэргэжилтэн ирсэн мэдээллийг программд бүрэн оруулахад цаг хугацаа, ажлын ачааллаас шалтгаалан мэдээллийг бүрэн оруулаагүйгээс нэгтгэсэн статистик тоо мэдээ зөрүүтэй байна.


¹⁴ Жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосугай.

3.3.8 Аймгийн 17 сумдын хурдан морьч уяач хүүхдийн талаарх мэдээлэл бүрэн бүртгэдэггүй зөвхөн Жаргалант сумын хэмжээнд зохион байгуулагдсан уралдаанд оролцсон хүүхдийн мэдээллийг оруулсан байна.

3.3.9 Эрсдэлтэй хүүхдийн мэдээллийн able программд 2019 онд 34 байсан бол 2023 онд 125 эрсдэлийг бүртгэснээс үзэхэд жилээс жилд хүүхэд хамгааллын үйлчилгээний эрэлт нэмэгдэж байна. Хүснэгт 11. Able программын мэдээлэл

эрсдэлийн төрөл	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
өндөр	13	4	65	64	24
дунд	5	9	144	39	30
бага		21	10	31	17
эрсдэлгүй	16	47	3	20	54
нийт эрсдэлийн дүн	34	81	222	154	125

3.3.10 Эрсдэлийн өсөлт бууралтыг хувиар харуулбал өндөр эрсдэл 2023 онд 19.2 хувь болж өмнөх оноос 22.4 хувиар, дунд эрсдэл 1.3 хувь, бага эрсдэл 6.5 хувиар тус тус буурсан, эрсдэлгүй кейсийн тоо өмнөх оноос 30.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. График 2 Эрсдэлийн



Хүүхэд хамгааллын тогтолцоонд мэдээллийн удирдлагын нэгдсэн систем байхгүйгээс хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх мэдээллийг цаг тухай бүрд нь үйлчилгээ үзүүлэгч бусад талтай хуваалцах, кейсийн үр дүнг үнэлэх, дараагийн үйлчилгээг оновчтой төлөвлөх, үйлчилгээний үр дүнг үнэлэхэд бэрхшээлтэй байна.

3.3.11 Эрсдэлт нөхцөл дэх хүүхдийг бүртгэх, мэдээллийн сан үүсгэдэг able программд оруулсан эрсдэлийг үнэлэхэд асуумж нь ойлгомжгүй, энгийн биш, зарим асуултууд нь тухайн нөхцөл байдалд уялдаагүй, ач холбогдолгүй байгаа нь эрсдэлийг үнэлж дүгнэхэд хүндрэлтэй байна.


Хүүхдийн эсрэг гэмт хэргийн суурь судалгаагүй, сургалт, арга зүйн зөвлөгөө өгөгдсөн ч салбар бүр хүүхэд хамгаалалтай холбоотой тоон үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж эрсдэлийг тооцох боломжгүй байна.

3.4.1 Аймгийн ИТХ-ын дэргэдэх ГХУСЗ, Цагдаагийн газар, ХГБХХГ-тай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор өмнөх онуудын статистик мэдээнд тандалт судалгаа хийх, сургалт сурталчилгаа хийх ажлуудыг тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллажээ.

3.4.2 Аймгийн хэмжээнд 2023 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо өмнөх оноос 63-аар, гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүн 9-өөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 9 Гэмт хэргийн тоо мэдээлэл

3.4.3 Аймгийн ГХУСАЗСЗ, Цагдаагийн газар, Прокурорын газар, ХГБХХГ-тай хамтран хүүхдийг гэмт хэрэг холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “сурагчийн аюулгүй байдал” ном хэвлүүлэн олгосон, сургалт сурталчилгааг зохион байгуулан аймаг, сумдын ЕБС, хамтран багуудын гишүүдийг оролцуулсан байна.



Эх сурвалж нь: Аймгийн Цагдаагийн байгууллагын судалгаа

3.4.5 Гэмт хэргийн төрлөөр авч үзвэл 2023 онд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2023 оныг 2019 онтой харьцуулахад 3.3 дахин өссөн, хулгайлах гэмт хэрэг 2.3 дахин буурсан бол олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах, мансууруулах гэмт хэрэгт хүүхэд холбогдоогүй байна.

Хүснэгт 12 Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн хэргийг Эрүүгийн хуульд заасан бүлгээр

Гэмт хэргийн төрөл	2019	2020	2021	2022	2023
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	3	2	4	9	11
Хүчиндэх	2	1			3
Хулгайлах	33	9	12	5	14
Залилах		2		1	2
Дээрэмдэх	6	1	3	2	
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах					
Мансууруулах					
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг		1			
Бусад	4	3	5		3

Эх сурвалж нь: Аймгийн Цагдаагийн байгууллагын судалгаа

3.4.6 Аймгийн Засаг даргын үйл ажиллагаа хөтөлбөр, ИТХ-ын ГХУСАЗСЗ-тэй хамтран 2019-2023 оны хооронд хийх ажлын төлөвлөгөөнд тусгасан дагуу орон нутагт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймаг, сумдын гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулахад орон нутгийн төсөвт 5.4 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөн баталж, 70 хувьтай хэрэгжиж байна.

3.4.7 Аймгийн прокурорын газраас “Хүүхдийн эрх” нэгдсэн аяны хүрээнд тус аймгийн ГХУСАЗСЗ, ХГБХХГ-тай хамтран хүүхдийн эрхийн талаарх хууль тогтоомж, журам, стандартын хэрэгжилтийг хангахад хамтын ажиллагааг сайжруулах, хүүхдийн эрхийн асуудлаар талуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сургалт сурталчилгааг зохион байгуулжээ.

3.4.8 Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын хэрэгжүүлэх ажлуудыг хүүхдийн төлөө зөвлөлийн дүрэмд салбарын бүрээр нарийн тусгагдсан ч бодлого хэрэгжүүлдэг аймгийн ХГБХХГазар болон төрийн байгууллагууд, сум, баг бүрээр нэгтгэсэн тоо мэдээлэл хангалттай хэмжээнд байхгүйгээс дүн шинжилгээ хийж эрсдэлийг тооцох боломжгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Аймаг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой асуудлыг “Алсын хараа 2050”, ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан баталсан байна
- Байгууллагын бүтэц орон тоог ТЕЗ-ийн шийдвэрээр баталсан ч төрийн албан хаагчид олон дахин солигдсон, хүний нөөцийн тогтвортой ажиллах нөхцөл хангагдаагүй байна.
- Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхдийн эрхийн талаар мэдээллийн сан бүрдүүлж, ашиглах, мэдээллийг нэгтгэх аргачлалыг мөрдөж ажиллаагүйгээс аймгийн ХГБХХГ-ын хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийн сан иж бүрэн бус, тоон мэдээлэл зөрүүтэй байна.
- Төсвийн төсөл боловсруулахад мөрдөх аргачлал, журам зааваргүйгээс өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байсан бол 2023 оноос зардлын норматив аргачлал батлагдаж хүүхэд хамгааллын үйлчилгээний зардал 2019 оныхоос 4.8 дахин өссөн байна.
- Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлын тооцох журамд хувьсах зардлын дундаж норматив 60,680 төгрөг байгааг эдийн засгийн инфляцтай уялдан нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- Шилэн дансны тухай хуульд заасан орлогын 30 ажил гүйлгээ, зарлагын 19 ажил гүйлгээг shilendans.gov.mn цахим сайтад ил тод мэдээлээгүй байна.
- ОУБ-аас олгогдсон эх үүсвэрээр түр хамгаалах байрны тохижилт тоног төхөөрөмжөөр хангагдсан ч зарим засвар үйлчилгээний ажил бүрэн хийгдээгүй, УТХО болон ОНХО-аар хийгдсэн ажлуудыг хүлээлгэн өгсөн эсэх нь тодорхой бус, хандивлагч байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй байна.
- Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн тухай хууль болон аймгийн Засаг даргын захирамжаар салбар зөвлөлийн гишүүдийн ажлын чиг үүрэг, хууль зүйн хороо, хамтарсан багийн хийх ажлыг тусгасан ч зарим хамтарсан багуудын тухайн онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, тайлангүй байгаа нь салбар хоорондын уялдаа хангагдаагүй байна.
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмын заалтуудыг мөрдөөгүй тогтоол, захирамж, тушаалд тухайн иргэн, хүүхдийн мэдээллийг дэлгэрэнгүй бичиж нийтэд ил мэдээлсэн нь хувь хүний мэдээллийг нууцлах асуудал хангалтгүй байна.
- Хүүхдийн эрхийг хамгааллын талаар хэрэгжүүлсэн хяналтын сул, бодлогын баримт бичиггүй, үр дүнг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлалгүйгээс хэрэгжилт үр нөлөө тодорхойгүй байна.
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний тоон мэдээнд дүн шинжилгээ хэрэгжүүлэн бодлого боловсруулж, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.
- Боловсрол салбарт мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдсанаар сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээнд эерэг нөлөөлөл бий болж, хүүхэд хамгааллын статистик мэдээг нэгтгэн гаргадаг үр дүн бий болж байна
- Эрүүл мэнд, соёл, спорт, хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагуудтай хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн бодлогын үр нөлөө тодорхойлон ажиллах шаардлагатай байна

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргэж байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргад:

- Хүүхдийн төлөө зөвлөлийн тайланг хуульд заасан хугацаанд ИТХ-аар хэлэлцүүлэн, шаардлагатай эх үүсвэрийг орон нутгийн төсөвт тусгуулан бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллах

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн дарга, Аймгийн Засаг даргад:

- Хүүхдийн төлөө зөвлөлийн хийх ажлын төлөвлөгөөг батлан, 3 дугаар улиралд багтаан хүүхэд хамгааллын тайланг Аймгийн ИТХ-д тайлагнаж ажиллах,
- Салбар хоорондын ажлын уялдааг сайжруулах, хүүхдийн төлөө зөвлөлийн дүрэмд тусгагдсан чиг үүргийн дагуу төрийн байгууллагуудын хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг хэлэлцэн үр дүнг тооцон ажиллах,

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Түнжээ:

- Байгууллагын статистик тоо мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан бусад холбогдох мэдээ тайланг үнэн зөв гарган нэгтгэн гаргаж, албан хаагчдын ажлын үр дүнг сайжруулан ажиллах
- Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүдийн ажлын чиг үүрэгт заасан төрийн байгууллага, хууль зүйн хороо, хамтарсан багуудын ажлын уялдааг ханган ажиллаж, төлөвлөгөөний биелэлтийг бодиттой тайлагнаж ажиллах
- Хүний нөөцийн тогтвортой ажиллах нөхцөл бололцоогоор хангах, албан хаагчдыг чадавхжуулах, багаар ажиллах чадварыг сайжруулах талаар үе шаттай ажлуудыг хэрэгжүүлэн ажиллах
- Байгууллагын болон хувь иргэн, хүүхдийн нууцтай холбоотой мэдээллийг тушаал, шийдвэрт тусгахгүй байх, байгууллагын онцлогт тохируулан нууцын журам боловсруулан мөрдөн ажиллах
- Шилэн дансны хуульд заасан мэдээллийг тухай бүрд нь үнэн зөв мэдээлж хэвших
- Байгууллагын тухайн онд хөтлөгдөх хөтлөх нэрийн жагсаалтыг гаргах, байгууллагын дэргэдэх ББНШК-ын хурлаар хэлэлцүүлэн батлуулах, архив бичиг хэргийн стандарт мөрдөн ажиллах,
- ОУБ-ын төсөл хөтөлбөр, УТХО, ОНХО бусад эх үүсвэрээр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил, хөрөнгийг комисс томилон хүлээн авч, эд хариуцагч карт хөтлөх, хөрөнгийн тооллогыг холбогдох хууль журамд заасны дагуу бодитой нүд үзэж тоолох, үр дүнг тооцох
- Түр хамгаалах байраар үйлчлүүлж байгаа насанд хүрэгчдийн хоол хүнс болон бусад үйл ажиллагааны зардлыг бодитой тооцон аймгийн ИТХ-д уламжлан батлуулах

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ:



ХӨӨД АРМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталаж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд анхдагч гүйцэтгэлийн аудитын тайланг үзэж танилцлаа.

Төсөлд тусгагдан зүйлгүй холбоотой зарцуулалт байхгүй болов.

НАРИЙН БҮНЭЙЛЭГ
ДАРГА

Б.БАЯРСҮХ

Б. Ногоолбаатар
Хүндэтгэсэн
Х. Баясгалант
2024.10.15

13-0304-43



ХОВД АЙМАГ
ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ГАЗАР

84140 Ховд, Жаргалант сум, Ховд аймаг

Tel: 7043-2922

E-mail: Khovd@fcy.gov.mn

2024 10.17 № 344

танай _____ -ны № _____ -т

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Х.БОЛДБААТАР ТАНАА

Танай газраас ирүүлсэн 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 382 дугаар албан бичгийн тайлангийн төсөлтэй танилцан хариу тайлбарыг хүргүүлж байна.

Хавсралт  хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Д.ТҮНЖЭЭ



ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР :

д/д	Саналын дугаар	Тайлбар
1	1.2.4	Саналыг хүлээн авч найруулга засварласан.
2	1.2.5	Ирүүлсэн нотлох баримтуудаар нотлогдохгүй байгаа тул хүлээн авах боломжгүй
3	1.2.10	2019-2023 онуудын мэдээллийн сангийн баримтуудаар ирүүлсэн мэдээний тоо баримт бодиттой, иж бүрэн бус тул хүлээн авах боломжгүй
4	2.2.8	Ажлын даалгаварт тусгагдсан зарим ажлуудыг хийгээгүй, хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй тул санал хүлээн авах боломжгүй
5	2.2.14	Саналыг хүлээн авч найруулга засварласан
6	2.2.15	Нууц хамгаалах журам байхгүй тул хүлээн авах боломжгүй
7	2.2.17	Хэрэгжүүлсэн тэмдэглэл, холбогдох нотлох баримтаар баталгаажиж байгаа тул хүлээн авах боломжгүй
8	3.1.5	Саналыг хүлээн авч найруулга засварласан.
9	3.3.7	Санал зөрүүгүй ижил агуулгатай тул засварлах шаардлагагүй
10	3.3.9	Санал зөрүүгүй 1 ижил агуулгатай тул засварлах шаардлагагүй
11	3.3.2	Санал хүлээн авах боломжгүй

АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ.

№	Аудитын чиглэл/асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (мянган,төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал	Гаргасан шийдвэр
А	1	3	4	5		9
1	Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хүний нөөц тогтвортой, орон тоо хүрэлцээтэй, мэргэшсэн албан хаагчид ажилладаг эсэх?	Сүүлийн 3 жилд байгууллагын дарга 3 , нягтлан бодогч 4, хүүхэд хамгааллын ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, хөгжил оролцоо хариуцсан мэргэжилтэн,захиргаа хүний нөөц хариуцсан мэргэжилтнүүд 1-2 удаа солигдож өөрчлөгдсөнөөс үзэхэд хүүхэд хамгааллын асуудал хариуцсан төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдээгүй, шинэ залуу ажилтныг сургах, хөгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөөгүй, байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт сулаас ажлын байрны тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл хангагдаагүй	-	зөвлөмж		зөвлөмж
2	Хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагааны мэдээлэл хаана нэгтгэгддэг вэ? Мэдээллийн нэгдсэн сан бүрдсэн эсэх?	Холбогдох хууль журамд зааснаар статистик мэдээллийн сан бүрдүүлэн үйл ажиллагаандаа ашиглах зохицуулалтай ч 2022 онд статистик мэдээ гаргах аргачлалыг баталсан ч одоог хүртэл үйл ажиллагаанд бүрэн ашиглаагүйгээс мэдээллийн сан бүрдүүлэлт хангалтгүй,	-	зөвлөмж		зөвлөмж
		ХГБХХГ-ын 2019-2023 онуудын байгууллагын үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, албан хаагчдын тухайн онуудад хэрэгжүүлсэн үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, бичмэл тайлан, статистик мэдээг он бүрээр нь нэгтгэсэн архивын нэгж үүсгээгүй, эмх цэгцгүй, байгууллагын тухайн онд хөтлөгдөх хөтлөх нэрийн жагсаалтыг гаргаж байгууллагын дэргэдэх БНШК-ын хурлаар хэлэлцүүлэн батлаагүйгээс үзэхэд хариуцсан албан хаагч нь ажлын байрны тодорхойлолт заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй	-	Сахилгын шийтгэл ноогдуулах албан шаардлага		Сахилгын шийтгэл ноогдуулах албан шаардлага
3	Хүүхэд хамгааллын талаар Олон улсын донор байгууллагын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтын тогтолцоо бүрдсэн үү?	УТХО-аар 2020 онд “Түр хамгаалах байр”-ны барилга ашиглалтад оруулсан барилгын бүх давхрын хана цууралт үүссэн, өвлийн улиралд маш хүйтэн, цонх, ханаарай дулаан алдалт ихтэй, барилгын суулт өгөгдсөн, 2021 оны УТХО-аар 70.0 гаруй сая төгрөгөөр гадна тоглоомын талбай, хашааг “Тусгал төв ХХК”-тай гэрээ байгуулсан уг ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгсөн эсэх нь тодорхой бус, Түр хамгаалах байрны ОО-ийн өрөөний суултуур, гар хатаагч, ХБИ-д зориулсан угаалтуур шүүгээний хамт 2.1 сая төгрөгийн өртөг хийгдсэн эсэх нь тодорхой бус,	72.0	албан шаардлага		албан шаардлага
		Баянбулаг зуслангийн гадна тохижилтын ажил гүйцэтгэхээр Эх нутгийн уулс ХХК-тэй 2023.07.31-ны өдөр хүлээлгэн өгөх 80.0 сая төгрөгийн гэрээт ажлын даалгаварт тусгагдсан хуурай хог байгуулах, саравч засварлах, дээвэр, цахилгаан монтаж камержуулалт засварлах ажлыг хийгээгүй, 20 гэрлийн шон суурилуулснаас 16 гэрлийн шон суурилуулсан, 13 шон хугарч эвдэрсэн, ашиглах боломжгүй	80.0			

		аймгийн ОНХО-аар Баянбулаг зусланд ямар ажил хийж гүйцэтгэх зураг төсөвгүй, гадна тохижилт хийх ажлын даалгаварт тусгагдсан ажлаа бүрэн хийгээгүй, байгууллагын даргын тушаалаар комисс томилон хүлээн авсан дотоод хяналт хэрэгжээгүй	5.4	төлбөрийн акт		төлбөрийн акт
4	Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн хувь хүний нууц бүрэн хамгаалагддаг уу?	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмын заалтуудыг мөрдөөгүй тогтоол, захирамж, тушаалд тухайн иргэн, хүүхдийн мэдээллийг дэлгэрэнгүй бичиж нийтэд ил мэдээлсэн нь хувь хүний мэдээллийг нууцлах асуудал хангалтгүй, “Байгууллагын нууцын тухай” хуульд тухайн байгууллагын нууцыг хамгаалах журмыг өөрийн байгууллагын онцлогт нийцүүлэн тогтоохоор заасан ч ХГБХХГазар нь байгууллагын нууцыг хамгаалах талаар журам боловсруулаагүй Хүүхэд хамгааллын үйлчилгээний зарлагын ажил гүйлгээний санхүүгийн анхан шатны баримтад төсвийн шууд захирагчийн тушаал, хүүхэд хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтний тайланд хүүхдийн овог нэр, регистрийн дугаар, хүүхэд, иргэний нэр, иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсарган архивын нэгж үүсгэсэн, аймгийн ИТХ-ын болон Засаг даргын захирамжаар өмгөөлөгчийн зардал гаргах шийдвэрт хүүхдийн овог нэр, регистрийн дугаар бичиж гаргасан, тухайн захирамж шийдвэрүүдийг khovd.gov.mn цахим сайтад ил тод байршуулж зэрэг нь “Хүний хувийн мэдээлэл хамгаалалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 -д заасан заалттай нийцэхгүй	-	зөвлөмж		зөвлөмж
5	Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ үнэлгээг бодитой хийж үнэн зөв тайлагнаж байна уу?	Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүдийн чиг үүргийг тодорхой заасан ч салбар хоорондын ажлын уялдаа хангалтгүйгээс тухайн онуудад хийх ажлын төлөвлөгөө боловсруулсан болон хэрэгжүүлэн ажил, хэлэлцсэн болон, шийдвэрлэсэн асуудал, ажлын тайлан мэдээгүй	-	зөвлөмж		зөвлөмж
6	Хүүхэд хамгааллын чиглэлээр зарцуулсан санхүүжилт, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан уу?	2023 онд байгууллагын даргын тушаал, удирдамж, төсвийг үндэслэн 40.1 сая төгрөгийн ажил гүйлгээг сургалтад оролцсон бүртгэлгүй, гүйцэтгэлийн тайлангүй, тэмдэглэлийн дэвтэр, балт 2022 онд 11.7, 2023 онд 3.2 сая, сургалтын цай хоолны зардалд 2022 онд 8.2, 2023 онд 26.1 сая төгрөгийг зарцуулсан нь		зөвлөмж		зөвлөмж
		2023 онд 5, 11 дүгээр саруудад хүнсний багц тараасан 2023 оны 2 дугаар сарын хүүхдийн нэрс, зураг давхацсан, ажлын тайлангүй дотоод хяналт хэрэгжүүлээгүй	5.8	төлбөрийн акт		төлбөрийн акт
		2022-2023 онуудын хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт зохион байгуулах зардлыг аж ахуйн нэгж байгууллага, хувь хүний төлбөрийг шилжүүлэн буцаан авч ямар үйл ажиллагаанд зарцуулсан эсэх нь тодорхойгүй	7.1	төлбөрийн акт		төлбөрийн акт
		Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын ажил гүйлгээний анхан шатны баримтгүй, бараа материал худалдан авсан ч эд хариуцагчийн тайлан гаргаагүй, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3 үйлдэлт принтерийг данс бүртгэлд тусгаагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй, бүртгэлээр тавих хяналт сул,	7.6	албан шаардлага		албан шаардлага

		Нэмэлт санхүүжилтийн данснаас 2022 оны 05 дугаар сарын 04-нд Аргалант мөнхөд ногоон ХХК-аас, 2022 оны 10 дугаар сарын 11-нд хувь хүний харилцах данс руу хүлэмж худалдан авснаар төлбөрийг шилжүүлэн данс бүртгэлд тусгасан ч бодитоор оршин байхгүй, Орон нутгийн хөрөнгөөр аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан хийсэн тор татах ажлыг гүйцэтгэсэн, Ачлал алаг хайрхан ХХК-аас төмөр тор 12 метр, өргөстэй тор 10 боодол нийт 3570.0 мянган төгрөгөөр худалдан авсан эсэх нь тодорхой бус	6.1	төлбөрийн акт		төлбөрийн акт
6	Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалт нь ил тод тайлагнадаг эсэх?	Шилэн дансны тухай хуульд заасан орлогын 30 ажил гүйлгээ, зарлагын 19 ажил гүйлгээг shilendans.gov.mn цахим сайтад ил тод мэдээлээгүй	-	зөвлөмж		зөвлөмж
7	Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай нөөцийг оновчтой тодорхойлж, зардлыг хуваарилж чадаж байна уу?	ХНХЯамны сайдын 2020 оны А/150 дугаар тушаалаар “түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлын тооцох” журам батлагдсан, нэг хүнд ногдох хувьсах зардлын дундаж норматив 60,680 төгрөг байгаа нь эдийн засгийн инфляцтай уялдаагүй, журмын 5.1 -д зааснаар тарифыг шинэчлээгүй	-	зөвлөмж		зөвлөмж
8	Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ үнэлгээг бодитой хийж үнэн зөв тайлагнаж байна уу?	хүүхдийн төлөө зөвлөл бодлогын хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэн, холбогдох байгууллагуудад шийдвэр зөвлөмж хүргүүлэхээр хуульчилсан ч өмнөх онуудад хэлэлцсэн асуудал, хэрэгжүүлсэн хяналтын талаарх мэдээлэл аудитад ирүүлсэнгүй, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дараах ажлуудыг хэрэгжүүлсэн ч хэрэгжүүлсэн хяналтаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг тооцоогүй	-	зөвлөмж		зөвлөмж
9	Монгол Улс Хүүхдийн эрхийн олон улсын конвенцод нэгдсэн үүргийг хангалттай хэрэгжүүлдэг үү?	2019, 2021 онуудад хурдан морь унаач хүүхдийн хамгаалах хэрэгсэл худалдан авч 50 хувийн хөнгөлөлттэйгөөр олгоод бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай тооцоо бодоогүй дотоод хяналт хэрэгжүүлээгүй	-	зөвлөмж		зөвлөмж
10	Хүүхдийн эсрэг гэмт хэргийн суурь шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч чадаж байна уу?	эрүүл мэнд, соёл, спорт, хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагуудтай хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн бодлогын үр нөлөө тодорхойгүй	-	зөвлөмж		зөвлөмж
11		Хүүхдийн эсрэг гэмт хэргийн суурь судалгаагүй, сургалт, арга зүйн зөвлөгөө өгөгдсөн ч салбар бүр хүүхэд хамгаалалтай холбоотой тоон үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж эрсдэлийг тооцох боломжгүй	-	зөвлөмж		зөвлөмж
Нийт дүн			184.0			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР